

ЧИНГЭЛТЭЙ СУРГАЛТ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВ

Нэг. ХӨМРӨГ ҮҮСГЭГЧ БАЙГУУЛЛАГЫН ТҮҮХ

1978 онд Улаанбаатар хотын АДХ-ын Гүйцэтгэх Захиргааны гишүүд, БНМАУ-ын Сангийн яам, Ардын боловсролын яамны коллегийн хамтарсан хурлын 257/291/325 тоот тогтоолын дагуу Сүхбаатар дүүргийн сургууль цэцэрлэгүүдийн нэгдсэн аж ахуйн төв нэртэйгээр байгуулагдан 1980-аад оны сүүл хүртэл үйл ажиллагаа нь явагдаж иржээ.

1990 Үндсэн хууль өөрчлөгдөж, түүнд нийцсэн “Аж ахуйн нэгж компанийн тухай” шинэ хууль гарснаар нэгдсэн аж ахуйн төвүүд бүтэц, зохион байгуулалтын хувьд өөрчлөгдөж, компанийн зохион байгуулалтаар ажиллах болсон билээ.

Чингэлтэй дүүргийн Сургалт үйлдвэрлэлийн төв нь дүүргийн цэцэрлэгүүдийг хоол хүнсээр хангахаас гадна дүүргийн сургуульд суралцах боломжгүй өрхийн хүүхдүүдийг сурган мэргэжил олгодог байжээ.

Дүүрэг бүрийн дэргэд ажиллаж байсан цэцэрлэг, сургуулиудын нэгдсэн аж ахуйн төвүүд татан буугдаж, дүүрэг бүрийн Засаг даргын захирамжаар тус бүрдээ “Бүрэн бус хариуцлагатай компани”-ууд байгуулагдаж, дүүргийн Засаг даргын захирамжаар компанийн захирлыг тус бүрд нь томилсон байна.

1992 оноос Бүгд найрамдах Монгол ард улсын “Аж ахуй нэгжийн тухай “шинэ хуулийн дагуу “Чингэлтэйн үйлдвэр сургалтын төв ” нэртэй компани болж захирлаар нь Лхамаасүрэн томилогдон ажиллаж байжээ. Улс орон зах зээлийн харилцаанд шилжих шилжилтийн он жилүүдэд тус аж ахуй нэгж үйл ажиллагаагаа мөн зах зээлийн зарчимд шилжүүлж ажиллах шаардлага зүй ёсоор тавигдаж байжээ.

Чингэлтэй үйлдвэр сургалтын төв нь Чингэлтэй дүүргийн 21 цэцэрлэгт үйлчилж 3000 гаруй хүүхдэд хүнсний бүтээгдэхүүнийг бэлтгэн нийлүүлдэг хангамж үйлчилгээг хариуцахын зэрэгцээ төсвийн байгууллагуудын гал тогооны тоног төхөөрөмжийн хэвийн найдвартай ажиллагааг засвар үйлчилгээ сэлбэг хэрэгсэл, тоног төхөөрөмж, аж ахуйн чанартай бараа бүтээгдэхүүнийг бэлтгэн нийлүүлэх чиг үүрэгтэй байгууллага юм.

Үйл ажиллагаагаа дүүргийн засаг дарга, нийслэлийн өмчийн харилцааны газрын өмнө хариуцан явуулж тайлагнаж дүгнүүлдэг байжээ.

Байгууллагын бүтэц орон тооны хувьд захирал, нягтлан бодогч, аж ахуйн нярав, түгээлтийн жолооч 2, бичиг хэрэг бэлэн мөнгөний нярав сахиул зэрэг 9 ажилтан ажиллаж байна.

Дээрх компаниудын үйл ажиллагаа жилээс жилд өргөжиж хөрөнгө санхүү эргэлтийн хөрөнгийн хувьд томоохон өөрчлөлт гарч түүнтэй холбогдох хуулиудад зохих өөрчлөлтүүд орсноор 1997 оноос компаниудын харъяалал, өмч хөрөнгө нийслэлийн өмчид бүртгэгдэх болсноор Нийслэлийн өмчит үйлдвэрийн газрууд болсон. Иймээс дээрх үйлдвэрийн газрын өмч хөрөнгийг захиран зарцуулах ерөнхий эрх нь Нийслэлийн Иргэдийн Хурал, Нийслэлийн Засаг даргад шилжсэн байна.

Ингээд Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2005 оны 06 дугаар сарын 124 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2005 оны 7 дугаар сарын 15-ний

өдрийн 282 дугаар захирамжаар татан буулгасан. Ингэж татан буулгасан боловч дүүргийн засаг даргын захирамжаар үйл ажиллагаагаа хэвийн явуулсаар байсан.

НИТХТэргүүлэгчдийн 2006 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 154 дүгээр тогоолоор 2 дүүргийн хангамжийн газруудыг нэгтгэн “Багачууд хүнс” НӨҮГ нэртэйгээр үйл ажиллагаа нь үргэлжилж байна.

“ Чингэлтэйн сургалт үйлдвэрлэл”УҮГ
/Баримтын төрлөөр/
1992-2005

А		
1	Албан бичиг	
2	Ирсэн бичиг	
3	Явсан бичиг	
4	Аудитын тайлан	42
Д		
	Дотоод журам	40
Н		
	Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан	5,10,17,26,31,36,45,53
С		
	Санхүүгийн тайлан	4,9,16,25,30,35,44,52
5		
Т		
6	Тушаал	1,3,6,11,18,27,33,38,46
7	Төлөвлөгөө	13,20,22,28,48,49,
8	Тайлан	14,21,23,41,47
Ү		
11	Үр дүнгийн гэрээ	7,12,19,39,
12	Үндсэн хөрөнгийн тооллого	2,32,37,54
14		
Ш		
15	Шалгалтын баримт	8,15,24,29,34,43,51